



“МАЛ ХАМГААЛАХ САН”-ИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын ДАРГА,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: ekhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Төмөрхүү
Утас: 261885
Цахим хаяг:

Аудитор: Н.Нямдаваа
Утас: 260512
Цахим хаяг:
nyamdavaan@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар

Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2016 оны 3 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан



МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН ЗАХИРАЛ
П.МӨНХБАЯР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2016.03.25 № 3/559
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мал хамгаалах сангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Мал хамгаалах сангийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мал хамгаалах сангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2016\0325\SA G30.Docx

07058

УХА0122

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Дүгнэлтийн үндэслэл
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Мал хамгаалах сан”-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд (САГ-2016/16/СТА-ЗГТС) аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай, Өрийн удирдлагын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Мал хамгаалах сан”-ийн 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударгаилэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударгаилэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Үндэсний аудитын газрын үүрэг юм.

“Мал хамгаалах сан”-ийн 2015 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 03 дугаар сарын 06-наас 2016 оны 03 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн санхүүгийн аудитын газрын аудитор Н.Нямдаваа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Мал хамгаалах сан”-ийн 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 25-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2016 оны 03 дугаар сарын 06-наас 2016 оны 3 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2014 оны 3 дугаар сарын 25-нд “Мал хамгаалах сан”- удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Мал хамгаалах сан”-ийн төсвийн захирагч нь Төсвийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Өрийн удирдлагын тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоол, шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Төсвийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Өрийн удирдлагын тухай хуулиуд болон холбогдох хууль, тогтоол, шийдвэрийн хүрээнд Мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилтот

арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд техник технологийн болон эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх, зээлийн ашиглалтанд хяналт тавих, зээлийг эргэн төвлөрүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс гадна Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 394 дүгээр тогтоолоор “Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”, Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-н дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д сангийн дарга тус сангийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу “Мал хамгаалах сан”-ийн дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. “Мал хамгаалах сан”-ийн төсвийн захирагчийн 2015 оны төсвийг Хүнс хөдөө аж ахуйн ямаар батлуулан Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж, 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн ЗГ-ын 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журам”-ын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Мал хамгаалах сан”-ийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримтласан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ҮХААЯамны 2013 онд батлагдсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд уг баримт бичигт ямар нэгэн өөрчлөлт ороогүй байгаа байна.

“Мал хамгаалах сан”-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Мал хамгаалах сан”-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн Acolous програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдал:

“Мал хамгаалах сан”-ийн Материаллаг байдлыг төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд нийт зардал 27,822.3 сая төгрөгийн 1 хувиар буюу 278.2 сая төгрөгөөр тогтоолоо.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Мал хамгаалах сан”-ийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сан дахь 900019044 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэн төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

“Мал хамгаалах сан”-ийн төсвийн захирагч нь 2015 онд төсвөөс ноос, арьс ширний урамшуулал болон төслийн зээлд нийт 26,226.8 сая төгрөгийн санхүүжилт авч, төслийн зээлийн эргэн төлөлт 1,496.6 сая, зээлийн хүүгийн орлого 178.7 сая, үндсэн бус үйл ажиллагааны орлого 98.0 сая төгрөг, өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан өөрийн орлого 169.9 сая төгрөг нийт 28,170.0 сая төгрөгийн орлого, Ноос, арьс ширний урамшуулалд 26,657.3 сая төгрөг, төслийн зээлд 1,274.0 сая төгрөг, урсгал зардалд 266.2 сая төгрөг, үндсэн хөрөнгөнд 9.2 сая нийт 28,283.0 сая төгрөгийг зарцуулсан. Төсвөөс санхүүжигдсэн зардал 26,226.8 сая төгрөгөөр төсөвлөгдөж 26,226.8 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж 26,657.3 сая төгрөг, урсгал үйл ажиллагааны зардалд 280.6 сая төгрөг төсөвлөгдөж 266.2 сая төгрөг зарцуулж 14.4 сая төгрөгөөр хэмнэж 94.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангахаар арга хэмжээ авч ажиллан <http://www.shilendans.gov.mn/org/1254> цахим хуудсаар 2015 оны мэдээллийг цаг тухай бүрд нь оруулан ажилласан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Тооцоо нийлж баталгаажуулаагүй өглөг 14.5 сая, хугацаа хэтэрсэн зээлийн авлага 2,434.0 сая төгрөг, МУ-ын ЗГ-ын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 374 дүгээр тогтоолын 2-т “Мал хамгаалах сангийн орон тооны дээд хязгаарыг 12 хүртэл байхаар тогтоосугай” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй орон тоог хэтрүүлэн

ажилласан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Мал хамгаалах сан”-ийн 2015 оны санхүүгийн тайланматериаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, гадаад дотоод томилолт, зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, мөнгөн хөрөнгө 100 хувь, нийт зардал 96.4 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Материаллаг дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Санхүүгийн тайлант тусгагдсан нийт 13,368.5 сая төгрөгийн авлага тайлагнасанаас төслийн зээлийн авлага 12,972.3 сая төгрөгийн авлага байна. Үүнээс 10,086.8 сая төгрөгийн авлагыг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулж 3,041.6 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн, 359.7 сая төгрөгийн авлага хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй авлага тус тус байна.

Мөн зээлийн гэрээний дагуу эргэн төлөлтөөс түүвэрлэн үзэхэд тухайлбал: 2013 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 2013/01 дугаар гэрээ, 2013 оны оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 2013/01 дугаар гэрээний нэмэлт гэрээгээр “АТААСҮ” ХХК-тай нийт 450.0 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулж уг гэрээний 2.5 зүйлд заасан эргэн төлөх хуваарийн дагуу тайлант онд төлөх нийт зээлийн 30 хувийг төлөөгүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

Дээрхи зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, ЗГ-ын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 374 дугаар тогтоолын 3-т “Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах тайлагнах журам” 2.9.6-д “сангийн орлого төвлөрүүлэх, өр авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, гүйцэтгэлийн тайлагнах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон ЗГ-ын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 374 дугаар тогтоолын 3-т “Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах тайлагнах журам”-ийг мөрдөж ажиллах, Зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээнд заасан зээлдүүлэгчийн эрх үүргийн дагуу гэрээний гүйцэтгэлийг тухай бүр дүгнэж байх талаар зөвлөмж өгөх

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна.

1. Тус газар нь ҮХААЯамны 2013 онд батлагдсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд уг баримт бичигт ямар нэгэн өөрчлөлт ороогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж баталж мөрдөх талаар менежменийн захидалаар зөвлөмж өгөх.

2. Бусад өглөг дансанд нийт 14.5 сая өглөг тайлагнасан нь тооцоо нийлж баталгаажуулж мөн 9.9 сая төгрөгийн өглөг нь эзэн холбогдогч нь тодорхойгүй байна. ЗГ-ын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 374 дугаар тогтоолын 3-т "Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах тайлагнах журам" 2.9.6-д "сангийн орлого төвлөрүүлэх, өр авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, гүйцэтгэлийн тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4. "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЗГ-ын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 374 дугаар тогтоолын 3-т "Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах тайлагнах журам", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх

3. 2015 оны тайлант онд орон тоо гүйцэтгэлээр 14 байсан бөгөөд унаа хоолны хөнгөлөлтийг батлагдсан төсвөөс 3.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн ЗГ-ын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 374 дугаар тогтоолын 2-т "Мал хамгаалах сан"-ийн орон тооны дээд хязгаарыг 12 хүртэл байхаар тогтоосугай" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй

Шийдвэрлэсэн: ЗГ-ын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 374 дугаар тогтоолын 2-т "Мал хамгаалах сангийн орон тооны дээд хязгаарыг 12 хүртэл байхаар тогтоосугай" гэсэн заалтыг хэрэгжүүлж батлагдсан орон тоогоор ажиллах, зөвлөмж өгөх

4. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад зардлын данснаас бичиг хэрэг, шуудан холбооны төлбөрт 1.3 сая төгрөгийн зардал, тээвэр шатахууны зардлын данснаас 1.7 сая төгрөгийн томилолтын зардал тус тус гарсан байна. Дээрх нийт 3.0 сая төгрөгийн зардал нь Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Батлагдсан төсвийг Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалын хүрээнд зарцуулах талаар зөвлөмж өгөх

5. 2015 оны аудитын албан шаардлагын дагуу 2014 онд 20 аж ахуй нэгж иргэнтэй байгуулсан 31 ширхэг 685.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээнд нийт төлбөрийг хамгийн багадаа өртгийг нөхөж байхаар нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага хүргүүлсэнээс Сайн эрийн хонхор ХХК, иргэн Н.Баднаагарав нарийн 2 ширхэг 49.7 сая төгрөгийн гэрээг шинэчлэн байгуулаагүй байгаа нь Түрээсийн гэрээний төлбөр тооцооны нөхцөл нь ЗГ-ын 2001 оны 134 дүгээр тогтоол Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам 3-т "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн хуулийн этгээдэд

түрээсээр эзэмшүүлэх зорилго нь төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн ЗГ-ын 2001 оны 134 дүгээр тогтоол Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журамд нийцүүлэн холбогдох арга хэмжээ авах талаар зөвлөмж өгөх

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Мал хамгаалах сан”-ийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Мал хамгаалах сан”-ийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тайлагнасанаас төслийн зээлийн авлага 12,972.3 сая төгрөгийн авлага байна. Үүнээс 10,086.8 сая төгрөгийн авлагыг харилцагчтай тооцоо нийлж баталгаажаагүй, 3,041.6 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн, 359.7 сая төгрөгийн авлага хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул шүүхээс буцаасан авлага, 9.9 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй өглөг, Сайн эрийн хонхор ХХК, иргэн Н.Баднаагарав нарийн 2 ширхэг 49.7 сая төгрөгийн гэрээг шинэчлэн байгуулаагүй байгаа зэрэг нийт 10,146.4 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын хийсэн аудитаар 3 зөвлөмж бөгөөд эдгээр зөвлөмжийг 80 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мал хамгаалах сангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д

нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.



МАЛ ХАМГААЛАХ САН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Авлага

Асуудал 2
НББ-ийн бодлогын баримт бичиг

Асуудал 3
Зардал

Асуудал 4
Өглөг

Асуудал 5
Батлагдсан орон тоо

Асуудал 6
Түрээсийн тоног төхөөрөмж

2016 оны 3 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Мал хамгаалах сан”-ийн удирдлагад зориулжбэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил ньсанхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Мал хамгаалах сан”-ийн санхүүгийнхолбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Авлага**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Нийт 10,086.8 сая төгрөгийн авлагыг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулж төслийн зээлийн авлагаас 3,041.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн, 359.7 сая төгрөгийн авлага хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй авлага тус тус байна.

Мөн зээлийн гэрээний дагуу эргэн төлөлтөөс түүвэрлэн үзэхэд тухайлбал: 2013 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 2013/01 дугаар гэрээ, 2013 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 2013/01 дугаар гэрээний нэмэлт гэрээгээр “АТААСҮ” ХХК-тай нийт 450.0 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулж уг гэрээний 2.5 зүйлд заасан эргэн төлөх хуваарийн дагуу тайлант онд төлөх нийт зээлийн 30 хувийг төлөөгүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байгаа нь ЗГ-ын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 374 дугаар тогтоолын 3-т "Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах тайлагнах журам" 2.9.6-д "сангийн орлого төвлөрүүлэх, өр авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, гүйцэтгэлийн тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон ЗГ-ын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 374 дугаар тогтоолын 3-т "Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах тайлагнах журам" 2.9.6-д "сангийн орлого төвлөрүүлэх, өр авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, гүйцэтгэлийн тайлагнах" гэсэн заалтыг хэрэгжүүлж арга хэмжээ авч ажиллах

Зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээнд заасан зээлдүүлэгчийн эрх үүргийн дагуу гэрээний гүйцэтгэлийг тухай бүр дүгнэж байх

Эрсдэлүүд

Дүрэм журмыг зөрчих, найдваргүй авлага өсөх,

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр хариу баталгаажуулсан болно.

Асуудал 2: Бодлогын баримт бичиг	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тус газар нь ҮХААЯамны 2013 онд батлагдсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд уг баримт бичигт ямар нэгэн өөрчлөлт ороогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж баталж мөрдөх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

Төсвийн захирагчийн хариу

Нягтлан бодох бүртгэлийн тухай шинэчилсэн хуультай холбогдуулан ХХААЯамнаас нэгдсэн бодлогын баримт бичгийг боловсруулахаар байна.

Асуудал 3: Зардал	Тэргүүлэх ач холбогдол №1
--------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад зардлын данснаас бичиг хэрэг, шуудан холбооны төлбөрт 1.3 сая төгрөгийн зардал, тээвэр шатахууны зардлын данснаас 1.7 сая төгрөгийн томилолтын зардал тус тус гарсан байна. Дээрх нийт 3.0 сая төгрөгийн зардал нь Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалын дагуу төсвийг зарцуулах

Эрсдэлүүд

Хууль, дүрэм журмыг зөрчих

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр хариу баталгаажуулсан болно.

Асуудал 4: Өглөг**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Бусад өглөг дансанд нийт тооцоо нийлж баталгаажуулж 14.5 сая өглөг тайлагнасанаас 9.9 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй байна. ЗГ-ын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 374 дугаар тогтоолын 3-т "Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах тайлагнах журам" 2.9.6-д "сангийн орлого төвлөрүүлэх, өр авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, гүйцэтгэлийн тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4. "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Хууль зөрчих Санхүүгийн тайлан, буруу илэрхийлэгдэх

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, эзэн холбогдогчгүй өглөгийг барагдуулах

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр хариу баталгаажуулсан болно.

Асуудал 5: Батлагдсан орон тоо**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

2015 оны тайлант онд орон тоо гүйцэтгэлээр 14 байсан бөгөөд унаа хоолны хөнгөлөлтийг батлагдсан төсвөөс 3.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн ЗГ-ын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 374 дугаар тогтоолын 2-т "Мал хамгаалах сан"-ийн орон тооны дээд хязгаарыг 12 хүртэл байхаар тогтоосугай" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан орон тоогоор ажиллах, унаа хоолны хөнгөлөлтийг хэтрүүлэн ажиллахгүй байх

Эрсдэлүүд

Урсгал зардал нэмэгдэх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр хариу
баталгажуулсан болно.

Асуудал 6: Түрээсийн тоног төхөөрөмж**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

2015 оны аудитын албан шаардлагын дагуу 2014 онд 20 аж ахуй нэгж, иргэнтэй байгуулсан 31 ширхэг 685.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээнд нийт төлбөрийг хамгийн багадаа өртгийг нөхөж байхаар нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага хүргүүлсэнээс Сайн эрийн хонхор ХХК, иргэн Н.Баднаагарав нарийн 2 ширхэг 49.7 сая төгрөгийн гэрээг шинэчлэн байгуулаагүй байгаа нь Түрээсийн гэрээний төлбөр тооцооны нөхцөл нь ЗГ-ын 2001 оны 134 дүгээр тогтоол Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам 3-т "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн хуулийн этгээдэд түрээсээр эзэмшүүлэх зорилго нь төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

ЗГ-ын 2001 оны 134 дүгээр тогтоол Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журамд нийцүүлэн холбогдох арга хэмжээ авах

Эрсдэлүүд

Дүрэм журам зөрчих, хөрөнгийн ашиглалт буурах

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр хариу
баталгажуулсан болно.

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАГНАЛЫН
ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС**

Аудитын нэр: “Мал хамгаалах санг”-ийн 2015 оны санхүүгийн тайлан

Аудитын код: УАГ-САГ/2015/21/СТА-ТС

Аудитын багийн нэр: Санхүүгийн аудитын газар

Тайлант жил : 2015 он

№	Аудитыг тайлагнах шатанд бүрдүүлэх баримтын нэр	Хяналт хийсэн огноо		Тайлбар
		Анхан шатныхянал т	Хоёрдах шатныхянал т	
1	Аудитын тайлан	✓	✓	
2	Ерөнхий аудиторoor гарын үсэг зуруулахаар бэлтгэсэн Аудитын гэрчилгээ	✓	✓	
3	Менежментийн захидал	✓	✓	
	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	✓	✓	
4	Санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай байгууллагыналбан бичиг болон санхүүгийн тайлан	✓	✓	
5	Акт, албан шаардлагын төсөл			Байхгүй
6	Хянан удирдах ажилтнуудын үүргийн хэрэгжилт			Байхгүй

Бэлтгэсэн: Аудитор

Н.Нямдаваа

Анхан шатны хяналт хийсэн аудитын менежер :

С.Төмөрхүү

Хоёрдах шатны хяналт хийсэн
САГ-ын ДАРГА Тэргүүлэх аудитор:

С.Энхзаяа

МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	547,640,700.00	52,107,000.00
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	547,640,700.00	52,107,000.00
АВЛАГА	13,392,657,417.23	13,368,480,421.15
Бусад авлага	13,392,657,417.23	13,368,480,421.15
БАРАА МАТЕРИАЛ	3,400,093,078.54	9,837,118,814.87
Бэлэн бүтээгдэхүүн	1,253,206,510.10	7,744,772,330.44
Хангамжийн материал	5,152,782.01	8,006,698.00
Мал, амьтад	2,141,733,786.43	2,084,339,786.43
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,340,391,195.77	23,257,706,236.02
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,492,702,360.88	260,853,564.38
Биет хөрөнгө	7,487,735,799.88	258,736,897.70
Барилга, байгууламж	544,466,000.00	342,446,500.00
Хуримтлагдсан элэгдэл	(135,262,138.70)	(140,301,289.56)
Авто тээврийн хэрэгсэл	50,985,900.00	50,985,900.00
Хуримтлагдсан элэгдэл	(17,703,437.50)	(26,201,087.50)
Машин, тоног төхөөрөмж	7,229,546,775.52	38,460,080.01
Хуримтлагдсан элэгдэл	(201,487,661.40)	(23,948,678.31)
Тавилга, аж ахуйн эд хогшил	31,727,345.60	33,375,075.00
Хуримтлагдсан элэгдэл	(16,203,650.28)	(17,079,601.86)
Бусад үндсэн хөрөнгө	2,398,550.00	2,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(731,883.36)	(1,000,000.08)
Биет бус хөрөнгө	4,966,561.00	2,116,666.68
Програм хангамж	13,155,000.00	13,555,000.00
Хасагдуулга	(8,188,439.00)	(11,438,333.32)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,492,702,360.88	260,853,564.38
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	24,833,093,556.65	23,518,559,800.40
Богино хугацаат өр төлбөр	42,915,676.33	14,481,112.86
Өглөг	42,915,676.33	14,481,112.86
Бусад өглөг	42,915,676.33	14,481,112.86
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	42,915,676.33	14,481,112.86
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	42,915,676.33	14,481,112.86
Засгийн газрын оруулсан капитал	1,514,078,031.90	1,514,078,031.90

Өмнөх үеийн үр дүн	23,276,099,848.42	23,077,851,448.42
Тайлант үеийн үр дүн		(1,087,850,792.78)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	24,790,177,880.32	23,504,078,687.54
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	24,833,093,556.65	23,518,559,800.40

МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙНҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	Өмнөх он	Тайлант он
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Урсгал	1,582,840,000.00	26,226,845,009.00
Улсын төсвөөс	21,582,840,000.00	26,226,845,009.00
Бараа, үйлчилгээний орлого	6,396,400,425.19	506,985,766.64
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	224,196,820.19	505,201,516.64
Үндсэн үйл ажиллагааны орлого	224,196,820.19	234,988,485.48
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		182,504,528.16
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		87,708,503.00
Торгууль, төлбөрийн орлого		639,000.00
Хөрөнгийн орлого	6,172,203,605.00	1,784,250.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	27,979,240,425.19	26,734,469,775.64
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	437,125,431.22	513,496,312.30
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	170,040,340.17	191,339,600.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	153,107,709.25	172,378,000.00
Цалин	140,653,449.25	159,697,000.00
Унаа хоолны хөнгөлөлт	12,454,260.00	12,681,000.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	16,932,630.92	18,961,600.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	13,857,810.75	15,514,040.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	10,782,990.56	12,066,200.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,348,048.36	1,379,000.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,419,289.80	1,723,780.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	307,482.03	345,060.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,074,820.17	3,447,560.00
Гэрэл цахилгааны зардал		28,200.00
Хангамж, бараа материалын зардал	33,271,736.80	16,802,786.15
Бичиг хэргийн материал	2,880,575.00	3,078,975.00
Тээвэр, шатахууны зардал	25,055,795.60	6,183,000.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	4,434,062.20	3,539,876.15
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	901,304.00	4,000,935.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,853,500.00	6,637,800.00
Урсгал засвар	2,853,500.00	6,637,800.00
Томилолт, зочны зардал	29,226,409.40	19,554,630.00

Гадаад томилолтын зардал	10,054,209.40	
Дотоод томилолтын зардал	19,172,200.00	19,554,630.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	46,976,058.00	22,249,644.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,685,746.00	20,946,944.00
Даатгалын үйлчилгээний төлбөр		152,700.00
Тээврийн хэрэгслийн татвар		150,000.00
Газрын төлбөр	290,312.00	1,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	154,757,386.85	256,883,652.15
Бусад зардал	972,670.00	486,700.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	153,784,716.85	256,396,952.15
ТАТААС	20,666,785,892.20	26,722,378,709.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас		65,122,200.00
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд	20,666,785,892.20	26,657,256,509.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,373,100.00
Бусад урсгал шилжүүлэг		3,373,100.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		3,373,100.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,375,000.00	
Бусад хөрөнгө	20,375,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	21,124,286,323.42	27,239,248,121.30
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	6,854,954,101.77	(504,778,345.66)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	179,007,929.00	74.37
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	179,007,929.00	74.37
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
Бараа материал худалдсаны гарз	231,318,639.56	583,072,521.49
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	231,318,639.56	583,072,521.49
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	6,802,643,391.21	(1,087,850,792.78)

МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Тусламж, санхүүжилтын орлого	21,582,840,000.00	26,226,845,009.00
Улсын төсвөөс	21,582,840,000.00	26,226,845,009.00
Урсгал	21,582,840,000.00	26,226,845,009.00
Бараа, үйлчилгээний орлого	425,679,169.74	446,706,472.20
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	425,679,169.74	446,067,472.20
Үндсэн үйл ажиллагааны орлого	101,925,950.61	178,752,889.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	323,753,219.13	97,372,103.00
Өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан өөрийн орлого	-	169,942,480.20
Торгууль, төлбөрийн орлого	-	639,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	22,008,519,169.74	26,673,551,481.20
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	283,228,791.68	262,799,698.60
Ажиллагчидтай холбогдсон зардал	170,040,340.17	191,339,600.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	153,107,709.25	172,378,000.00
Цалин	140,338,209.25	159,697,000.00
Унаа хоолны хөнгөлөлт	12,769,500.00	12,681,000.00
Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	16,932,630.92	18,961,600.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	10,782,990.57	12,066,200.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,229,928.07	1,379,000.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,537,410.08	1,723,780.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	307,482.03	345,060.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,074,820.17	3,447,560.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	113,188,451.51	71,460,098.60
Байр ашиглалтайхолбоотой тогтмол зардал	-	28,200.00
Гэрэл цахилгааны зардал	-	28,200.00
Хангамж, бараа материалын зардал	33,159,814.11	27,742,344.60
Бичиг хэрэг	3,176,240.00	3,414,210.00
Тээвэр, шатахуун	24,400,700.00	6,593,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,428,068.11	3,603,299.60
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,154,806.00	14,131,835.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,853,500.00	6,647,800.00
Урсгал засвар	2,853,500.00	6,647,800.00
Томилолт, зочны зардал	29,226,409.40	19,554,630.00

Гадаад албан томилолт	10,054,209.40	-
Дотоод албан томилолт	19,172,200.00	19,554,630.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,976,058.00	17,000,424.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	46,685,746.00	15,697,724.00
Даатгалын үйлчилгээ	-	152,700.00
Тээврийн хэрэгслийн татвар	-	150,000.00
Газрын төлбөр	290,312.00	1,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	972,670.00	486,700.00
Бараа үйлчилгээний бусад зардал	972,670.00	486,700.00
ТАТААС	20,666,785,892.20	26,742,855,774.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	85,599,265.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	85,599,265.00
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,666,785,892.20	26,657,256,509.00
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,666,785,892.20	26,657,256,509.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	169,942,480.21	386,053,019.60
Засгийн газрын урсгал шилжүүлэг	169,942,480.21	382,679,919.60
Төвлөрүүлэх шилжүүлэг	169,942,480.21	382,679,919.60
Бусад урсгал шилжүүлэг	-	3,373,100.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,373,100.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	21,119,957,164.09	27,391,708,492.20
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	888,562,005.65	(718,157,011.00)
Хөрөнгийн орлого	-	1,496,623,311.00
Эргэн төлөлт	1,736,987,608.35	1,496,623,311.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	1,736,987,608.35	1,496,623,311.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	96,684,750.00	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	96,684,750.00	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	96,684,750.00	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	1,640,302,858.35	1,496,623,311.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙН ХАССАН ЗЭЭЛ	1,990,000,000.00	1,274,000,000.00
Эргэж төлөгдөх зээл	1,990,000,000.00	1,274,000,000.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	1,990,000,000.00	1,274,000,000.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	538,864,864.00	(495,533,700.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,775,836.00	547,640,700.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	547,640,700.00	52,107,000.00

МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙГДСЭНӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2014 оны 1-р сарын 1- ээрх үлдэгдэл	1,514,078,031.90	-	16,473,456,457.21	17,987,534,489.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,514,078,031.90	-	23,276,099,848.42	24,790,177,880.32
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(198,248,400.00)	(198,248,400.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,514,078,031.90	-	23,077,851,448.42	24,591,929,480.32
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,087,850,792.78)	(1,087,850,792.78)
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,514,078,031.90	-	21,990,000,655.64	23,504,078,687.54

**МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН 2015 ОНЫ
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,416,511,000.00	28,197,429,307.60	219,081,692.40	99.2
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	26,507,511,000.00	26,923,429,307.60	(415,918,307.60)	101.6
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	26,507,511,000.00	26,923,429,307.60	(415,918,307.60)	101.6
Бараа, үйлчилгээний зардал	277,165,900.00	262,799,698.60	14,366,201.40	94.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	172,378,000.00	172,378,000.00	0.00	100.0
Үндсэн цалин	163,270,000.00	159,697,000.00	3,573,000.00	97.8
Унаа, болон бусад нөхөн олговор	9,108,000.00	12,681,000.00	(3,573,000.00)	139.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,961,600.00	18,961,600.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	12,066,200.00	12,066,200.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	1,379,000.00	1,379,000.00	-	100.0
ҮОМШӨ ний даатгал	1,723,780.00	1,723,780.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	345,060.00	345,060.00	-	100.0
Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	3,447,560.00	3,447,560.00	0.00	100.0
Гэрэл цахилгаан	1,020,000.00	28,200.00	991,800.00	2.8
Хангамж, бараа материалын зардал	32,576,300.00	27,742,344.60	4,833,955.40	85.2
Бичиг хэрэг	3,400,000.00	3,414,210.00	(14,210.00)	100.4
Тээвэр (шатахуун)	6,600,000.00	6,593,000.00	7,000.00	99.9
Шуудан холбоо	5,500,000.00	3,603,299.60	1,896,700.40	65.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	17,076,300.00	14,131,835.00	2,944,465.00	82.8
Эд хогшил худалдан авах	8,500,000.00	6,647,800.00	1,852,200.00	78.2
Урсгал засвар	8,500,000.00	6,647,800.00	1,852,200.00	78.2
Дотоод албан томилолт	20,000,000.00	19,554,630.00	445,370.00	97.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	22,850,000.00	17,000,424.00	5,849,576.00	74.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	20,000,000.00	15,697,724.00	4,302,276.00	78.5
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000.00	-	1,500,000.00	-
Даатгалын үйлчилгээ	200,000.00	152,700.00	47,300.00	76.4
Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00	-	100.0
Газрын төлбөр	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	880,000.00	486,700.00	393,300.00	55.3
ТАТААС	26,226,845,100.00	26,657,256,509.00	(430,411,409.00)	101.6
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	26,226,845,100.00	26,657,256,509.00	430,411,409.00)	101.6
Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00	3,373,100.00	126,900.00	96.4

Эргэж төлөгдөх зээл	1,909,000,000.00	1,274,000,000.00	635,000,000.00	66.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,416,511,000.00	28,149,697,727.20	266,813,272.80	99.1
Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,189,665,900.00	1,824,841,615.20	364,824,284.80	83.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	98,011,103.00	(98,011,103.00)	-
Төсвөөс санхүүжих	26,226,845,100.00	26,226,845,009.00	91.00	100.0
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	547,640,700.00	(547,640,700.00)	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	52,107,000.00	(52,107,000.00)	-

“